

2017 ОНД МОНГОЛ УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛСАН ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙН ТООЦОО

1. Түр ажлын байр, цалин хөлс

906 хүнийг түр ажлын байраар хангаж **129,714,437 төгрөгийн** цалин хөлс олгосон.

2. Монгол улсад ирсэн гадны тамирчдын тоо

Монгол Улсад 2017 онд 8 тэмцээнд оролцох гэж дэлхийн 21 орны 695 тамирчин, 165 дасгалжуулагч, 205 албаны зочид 4-8 хоногоор ирсэн.

3. Олон улсын тээвэр

2017 онд Монгол улсад ирсэн нийт 1072 тамирчин, дасгалжуулагч, албаны зочдын 60% гаруй хувь нь олон улсын тээвэр эрхэлдэг Монголын Үндэсний тээвэрлэгч компаниар үйлчлүүлж ойролцоогоор **747 сая** төгрөгийн орлого оруулсан байна.

4. Дотоодын тээвэр

Тэмцээний үеэр хот доторх тээврийн үйлчилгээнд дотоодын тээврийн байгууллагуудаар үйлчлүүлж тэдгээрт **90 сая** орчим төгрөгийн орлого оруулсан.

5. Бэлэг дурсгал, худалдаа, үйлчилгээ

Тэмцээнд оролцохоор ирсэн баг тамирчид бэлэг дурсгал худалдан авахад **173 сая** орчим төгрөгийн орлого оруулсан.

6. Зочид буудал

Тэмцээнд оролцохоор ирсэн баг тамирчид Монгол Улсад байх хугацаандаа Улаанбаатар хотын зочид буудлуудад нийт **768 сая** төгрөгийн орлого оруулсан.

7. Билетийн орлого

Олон улсын тэмцээнүүдээс 2 тэмцээн тасалбар борлуулж **4637 үзэгч 43,6 сая** төгрөгийн тасалбар худалдан авч үзсэн.

8. Олон улсын тэмцээн зохион байгуулахад зарцуулсан төсөв

2017 онд 8 олон улсын тэмцээнийг зохион байгуулахад нийт **2,2 тэрбум** төгрөгийг зарцуулснаас Улсын төсвөөс **806 сая**, Спортын холбоод, ивээн тэтгэгчээс **826 сая**, Олон улсын байгууллагаас **100 сая** төгрөг зарцуулсаны дээр тэмцээний үйл ажиллагаанаас **518 сая** төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлж зохион байгуулалтад зарцуулсан байна.

9. Шууд дамжуулалт

Дээрх тэмцээнүүдээс 1 тэмцээн, 1 наадмыг интернэтээр дэлхийн **250 гаруй** оронд **70 орчим** цагийн шууд дамжуулалтыг хийж Монгол Улсыг сурталчилах үйл ажиллагааг хийсэн.

10. Хэмнэлт

Хэрэв дээрх 8 тэмцээнд Монгол Улсын баг тамирчид гадны улсад очиж оролцсон бол нийт нийт 358 тамирчин, дасгалжуулагчийн зардалд **561 сая** төгрөгийн зардлыг гадны улсын эдийн засагт оруулах байсан.

НИЙТ: Монгол Улсад дээрх 8 тэмцээнийг зохион байгуулснаар улсын төсвөөс зарцуулсан **806 сая** төгрөгөөс нэг дахин их буюу **1,6 тэрбум** төгрөгийн орлого гадны баг тамирчдаас манай улсын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд очсон байна.

Мөн эдгээр 8 тэмцээнийг зохион байгуулахад ивээн тэтгэгчдээс **400 сая** төгрөгийн хөрөнгийг төвлөрүүлсэн бол дээрх тэмцээнүүдийг зохион байгуулснаар **518 сая** төгрөгийн орлого төвлөрүүлж тэмцээний зохион байгуулалтад эргүүлэн зарцуулсан байна.

Монгол Улсад 2016 онд ЗГ-ын тогтоолоор нийт 12 тэмцээнийг зохион байгуулагдахад 1,2 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлж Монгол Улсын нийгэм-эдийн засагт 3,8 тэрбум төгрөгийн орлого оруулж байсан бол 2017 онд 8 тэмцээнд 806 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж 1,6 сая төгрөгийн орлого орсон байна.

Монгол Улсын нийгэм -эдийн засагт үзүүлсэн орлогоор 2016 оны оны үзүүлэлт өндөр байгаа нь 2016 онд Монгол Улсад олимпийн эрх олгох чөлөөт бөхийн, олимпийн эрхийн оноо олгох жүдо бөхийн тэмцээн болон тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнүүд зохион байгуулагдсантай шууд холбоотой юм.

Мөн 2017 онд санхүүжилтийн байдлаас болоод Бодибилдинг фитнесийн Ази тивийн аварга, Сагсан бөмбөгийн ази тивийн аварга зэрэг тэмцээнүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж чадаагүй болно.

**2017 он Монгол улсад зохион байгуулагдсан Олон улсын
чанартай тэмцээнүүдэд хийсэн судалгаа**

№	Тэмцээн	Монголд болсон тэмцээнд оролцсон Монгол тамирчны тоо	Гадаадад болох тэмцээнд оролцох тамирчдын тоо	Замын зардал дундаж /төг/	Гадны тэмцээнд оролцох хоног	Байр, хоолны төлбөр өдөрт дундажаар /төг/	Тэмцээний хураамж /хүн нэг бүрээр/	Хэмнэсэн нийт зардал /төг/
1	Шатарын Өсвөр үеийн Зүүн Азийн аварга шалгаруулах тэмцээн	250	60	1,500,000	7	144,000	120,000	157,680,000
2	Боксын насанд хүрэгчдийн "Улаанбаатарын цом" ОУ- ын тэмцээн	43	15	1,500,000	8	144,000	120,000	41,580,000
3	Чөлөөт бөх "Монголиа Опен"	127	20	1,500,000	6	144,000	240,000	52,080,000
4	Волейболын эрэгтэйчүүдийн Зүүн Азийн аварга шалгаруулах тэмцээн	24	24	1,500,000	8	144,000	120,000	66,528,000
5	Бадминтоны насанд хүрэгчид, өсвөр үеийнхний олон улсын цуврал тэмцээн	52	12	1,500,000	4	144,000	120,000	26,352,000
6	Софт теннисний өсвөр үеийн Азийн цомын тэмцээн	32	10	1,500,000	6	144,000	120,000	24,840,000
7	Аэробикийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн	60	20	1,500,000	5	144,000	120,000	46,800,000
8	Олон Улсын хүүхдийн спортын VII наадам	580	197	90,000	6	108,000	-	145,386,000
			358					561,246,000